

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	2
ХАМРАХ ХҮРЭЭ.....	3
БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	8
1.1. ТӨСЛИЙН БАЙРШИЛ, ОРЧНЫ ТОЙМ	8
1.2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АЖ АХУЙ НЭГЖИЙН МЭДЭЭЛЭЛ	8
1.3. УУРХАЙН ХҮЧИН ЧАДАЛ, ТЕХНОЛОГИЙН ГОРИМ	9
1.4. Уурхайн 2026 оны уулын ажлын төлөвлөгөө	12
1.5. ДЭД БҮТЭЦ	12
Унд ахуйн хэрэглээний ус ашиглалт.....	12
БҮЛЭГ 2. АШИГЛАЛТЫН ТАЛБАЙ ОРЧМЫН БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ХУРААНГУЙ.....	15
2.1. Талбайн газарзүйн байршил.....	15
2.2. Цаг уур амьсгалын үндсэн үзүүлэлтүүд	16
2.3. Хөрсөн бүрхэвч.....	18
2.4. Ургамлан нөмрөг.....	18
2.5. Амьтны аймаг.....	18
2.6. Усан орчны төлөв байдал.....	19
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	20
3.1. Агаарын чанарт учруулах сөрөг нөлөөлөл	20
3.2. Газрын гадарга болон хөрсөн бүрхэвчид учруулах сөрөг нөлөөлөл.....	20
3.3. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл	20
3.4. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөлөл	20
3.5. Газрын гадарга болон гүний усанд учруулах сөрөг нөлөөлөл.....	21
3.6. Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдал орчны эрүүл ахуйд сөргөөр нөлөөлөх	21
3.7. Нийгэм эдийн засагт учруулах эерэг болон сөрөг нөлөөлөл.....	21
БҮЛЭГ 4. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	22
“ХӨӨТИЙН ХОНХОР-2” УУРХАЙН 2025 ОНЫ ОРЧНЫ БОХИРДЛЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН.....	23
I. Агаарын чанарын судалгаа, шинжилгээний үр дүн.....	23
III. Усны чанарын хяналт-шинжилгээний үр дүн.....	26
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ХЭРЭГЖҮҮЛЭХ НИЙТ ЗАРДАЛ	27
1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	28
1.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	32
1.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	33
1.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	34
1.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох олгох төлөвлөгөө	36
1.6. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	36
1.7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	37
1.8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	39
БҮЛЭГ 5. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	40
5.1. АГААРЫН ЧАНАР.....	40
5.2. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УС.....	40
5.3. ХӨРСӨН БҮРХЭВЧ.....	41
5.4. УРГАМЛАН НӨМРӨГ.....	42
5.5. ДУУ ЧИМЭЭ ДОРГИО ЧИЧИРГЭЭ.....	42
БҮЛЭГ 6. БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ	43
ХАВСРАЛТ МАТЕРИАЛ	44

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн товч мэдээлэл	8
Хүснэгт 2. Ашиглалтын технологийн схем	9
Хүснэгт 3. Уурхайн үндсэн хэмжээсүүд.....	10
Хүснэгт 4. Уурхайд ашиглаж буй техник.....	11
Хүснэгт 5. Ил уурхайн автозамын үзүүлэлтүүд	11
Хүснэгт 6. Уурхайн 2026 оны Уулын ажлын төлөвлөгөөнд тооцсон ажиллах горим.....	12
Хүснэгт 7. 2024 онд унд ахуйн хэрэглээнд ашигласан усны тооцоо.....	12
Хүснэгт 8. Ногоон байгууламжын усалгаанд ашигласан усны хэрэглээ	13
Хүснэгт 9. Сарын агаарын дундаж температур	16
Хүснэгт 10. 2023, 2024 оны сарын нийлбэр хур тунадасны хэмжээ.....	17
Хүснэгт 11. Сарын салхины үнэмлэхүй хурд, м/с	17
Хүснэгт 12.....	17
Хүснэгт 13. Гидрогеологийн үндсэн үзүүлэлтүүд	19
Хүснэгт 14. Үүсэх хог хаягдлын төрөл	21
Хүснэгт 15. Орон нутгаас өгсөн санал.....	23
Хүснэгт 19- Усны химийн завлан шинжилгээний үр дүн.....	26
Хүснэгт 26. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал.....	27

ОРИЛ

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн MV-020772 дугаартай “Хөөтийн хонхор”-2 нэртэй нүүрсний ордыг ашиглах төслийн 2026 оны БОМТөлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, хянах батлах, тайлагнах журам”-ыг үндэслэн, төслийн 2024.06.06-нд батлагдсан БОННУ-ний нэмэлт тодотголын тайлан болон 2026 онд хэрэгжүүлэх уулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулж, тус төслийн 2025 онд хэрэгжүүлсэн БОМТөлөвлөгөөний биелэлтийг дүгнэх ажлын үед орон нутгаас өгсөн саналуудыг тусган боловсруулав.

Менежментийн төлөвлөгөө нь бүтэц агуулгын хувьд:

- Төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэл,
- Төслийн танилцуулга,
- Төсөл хэрэгжиж буй бүс нутгийн байгаль орчин нийгэм эдийн засгийн төлөв байдлын хураангуй,
- Төслөөс байгаль орчин, нийгэм эдийн засагт учруулах эерэг болон сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт,
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө,
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр гэсэн хэсгээс бүрдэнэ.

Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах үйлдвэр, үйлчилгээний аливаа төсөл нь байгаль орчны хуулиудаар тогтоосон хэм хэмжээ ба төрийн захиргааны байгууллагаас баталгаажуулсан стандарт, нормын шаардлагад нийцүүлэн хэрэгжих ёстой.

Тус төслийг төслийг хэрэгжүүлэх явцад дараах байгаль орчны хуулиуд, агаар, ус, хөрсний чанарын стандартуудыг дагаж мөрдөнө.

ХАМРАХ ХҮРЭЭ

Хуулийн заалт	Зүйл
Монгол улсын үндсэн хуулиас	
1. Монгол улсад газар, түүний хэвлий, ой, ус, ургамал, амьтан болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.	Монгол Улсын Үндсэн Хууль Зургаадугаар зүйл
2. Монгол улсад иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн.	
3. Төр газрын эзэд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлыг ашиг сонирхолд харшаар ашиглавал хурдан авч болно.	
4. Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн.	Арвандолдугаар зүйл
Байгаль орчныг хамгаалах тухай хуулиас	
Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдлаар байгаль орчныг бохирдуулахгүй байх талаар дараах үүрэгтэй.	Тавдугаар бүлэг Хориннэгдүгээр зүйл Байгаль орчныг бохирдохоос хамгаалах
1. Хог хаягдлыг ялган, зориулалтын саванд цуглуулан,	

тусгайлан тоноглогдсон тээврийн хэрэгслээр зөөж тогтоосон цэгт хаях.	
Аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэгтэй байна. 1. Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага болон засаг даргын шийдвэр, улсын байцаагч, байгаль хамгаалагчийн шаардлагыг биелүүлэх; 2. Бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, өөрийн	Гучиннэгдүгээр зүйл Аж ахуйн нэгж байгууллагын үүрэг
үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд ялгаруулж байгаа хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах үүрэг бүхий дотоод хяналтын нэгжтэй байх; 3. Өөрийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учруулсан хохирлыг арилгах, холбогдох байгууллагад мэдэгдэх, байгаль орчны хяналтын улсын байцаагчийн ногдуулсан нөхөн төлбөрийг ажлын 14 хоногт багтаан төлөх.	
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиас	
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байна; Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж буй өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгана. Байгаль орчныг хамгаалах тухайн жилийн төлөвлөгөө, орчны хяналт- шинжилгээний хөтөлбөр болон тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага батална.	Есдүгээр зүйл Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
Агаарын тухай хуулиас	
9.1.1 Агаар хамгаалахтай холбогдсон дүрэм, журам, бохирдуулах бодисын хаягдлын стандарт, хэм хэмжээний шаардлагыг хангах 9.1.2 Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ тухайн эх үүсвэрийн хаягдал, нөлөөллийг хянах дотоод хяналтын багаж хэрэгслээр тоноглох 9.1.3 Аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан орчны хяналт- шинжилгээний хөтөлбөрийн дагуу дотоод хяналтыг явуулах 9.1.4 Агаар хамгаалах талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвөлгөө авах 9.1.5 Агаарын бохирдлыг бууруулах талаар холбогдох хууль	Есдүгээр зүйл Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэг

тогтоомжийг дагаж мөрдөх 9.1.6 Агаарын бохирдлыг бууруулах техник, технологи, шингэрүүлсэн хийн түлш, бусад эх үүсвэрийг ашиглах	
17.1 Агаар бохирдуулах бодисын хүлцэх агууламж, агаарт үзүүлэх физикийн хортой нөлөөллийн түвшний хэм хэмжээ, түүнчлэн хөдөлгөөнт эх үүсвэрийн төрөл бүрээс агаарт гаргах бохирдуулах бодисын хүлцэх агууламж, физикийн хортой нөлөөллийн түвшний хэм хэмжээ, тэдгээрийг тодорхойлох аргыг стандартаар тогтооно.	Арвандолдугаар зүйл Агаар хамгаалахтай хэм хэмжээ
23.1 Аж ахуйн нэгж байгууллага нь ашиглалтанд орсон хугацааг харгалзахгүйгээр агаарт бохирдуулах бодис гаргадаг физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг эх үүсвэр нэг бүрээ хянах, агаар бохирдуулах бодисыг цэвэрлэх, физикийн хортой нөлөөллийг бууруулах тоног төхөөрөмж багаж хэрэгслээр тоноглоно. 23.2 Агаар бохирдуулах бодисыг цэвэрлэх, физикийн хортой нөлөөллийг бууруулах, эх үүсвэр бүрийг хяналтын тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр тоноглох, тэдгээрийн ашиглалтын байдалд тухайн салбарыг харьяалах, төрийн захиргааны төв байгууллага, сум дүүргийн Засаг дарга байгаль орчны байцаагч хяналт хийнэ.	Хорингуравдугаар зүйл Эх үүсвэрийг тоноглох
Газрын тухай хуулиас	
35.3.4. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тогтоосон журмын дагуу хийлгэж байх;	35 дугаар зүйл. Газар
55.1. Газрын хэвлийг ашиглахтай холбогдсон үйл ажиллагаа нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байна. 55.2. Газрын хэвлийг ашиглагч нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, газрыг хамгаалах, нөхөн сэргээх төсөлтэй байна.	Эзэмшигчийн эрх, үүрэг 55 дугаар зүйл. Газрын хэвлийг зохистой ашиглах, хамгаалах
Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль	
Төсөл хэрэгжүүлэгч нь тогтоосон цэгээс бусад газарт хөрсийг хог хаягдлаар бохирдуулахгүй байх, эрүүл ахуйн шаардлага хангасан бохир ус зайлуулах байгууламжтай байх, төслийн ажлын явцад болон дууссаны дараа эвдэрсэн газрын хөрсийг нөхөн сэргээх ёстой. Эзэмшлийн болон өмчлөлийн газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх, тогтоосон авто зогсоол болон авто замын зорчих хэсгээс бусад газарт тээврийн хэрэгсэл зогсоох, зорчихыг хориглох, үйл ажиллагааныхаа явцад доройтсон хөрсийг биологийн нөхөн сэргээлтийн стандартын шаардлагад нийцүүлэн нөхөн сэргээх, хөрсний ялзмаг, үржил шимийг тогтоох, доройтлоос хамгаалах зорилгоор гуу, жалга үүсэж болох газарт хаалт хамгаалалт хийх, ойжуулах ёстой.	7 дугаар зүйл. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээ
Байгалийн ургамлын тухай хуулиас	
7.1 Ургамлыг гал түймэр, өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавж болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах ажлыг бүх шатны Засаг дарга улсын төсвийн хөрөнгөөр, гэрээний дагуу газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ.	Долдугаар зүйл Ургамлыг хамгаалах

Галын аюулгүй байдлын тухай хуулиас	
1. Барилга байгууламжийн хийц, бүтээцийн шийдэл нь гал түймэр гарсан тохиолдолд хүн амын аюулгүй байдлыг хангахуйц, гал түймэрийг бага хохиролтойгоор унтраах бололцоог хангасан байна.	Арван наймдугаар зүйл Галын аюулгүй байдлыг хангах талаар тави х нийтлэг шаардлага
Хаягдал усыг зайлуулах цэг тогтоох журам	
1. Иргэн аж ахуйн нэгж, байгууллага нь үйлдвэр, ахуйн бохир усаа ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх боломжгүй тохиолдолд байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөхгүйгээр урьдчилан цэвэрлэж,халдваргүйжүүлэн, бэлтгэсэн цэг талбайд байрлуулна. 2. Хаягдал ус зайлуулах цэгийг байгаль орчин, эрүүл ахуй, халдвар судлалын байгууллагын дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын шийдвэрээр тогтооно. 3. Хаягдал ус зайлуулах цэг тогтоох журмыг зөрчвөл “Байгаль хамгаалах тухай” болон “Усны тухай” хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.	Нэг Нийтлэг үндэслэл
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль	
Төсөл хэрэгжүүлэгч нь уг хуульд заасны дагуу галын аюулгүй байдалд тавих шаардлагуудыг хангах болон ажилчдыг эрүүл мэндийн үзлэг, ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон мэргэжлийн сургалтыг зохион байгуулах ёстой. Мөн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцах ба үйлдвэрлэлийн явцад бий болсон хими, физик, биологийн хүчин зүйл нь ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, техник, зохион байгуулалтын арга	28 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар ажил олгогчийн эрх, үүрэг
хэмжээ авах, хөдөлмөр эрхлэлтийн явцад гарч болзошгүй осол, бэртэл, өвчлөлөөс ажилтныг хамгаалах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежмент нэвтрүүлэх, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ гаргуулах ёстой.	

Стандарт, норм, норматив

№	Дугаар	Нэр
1	MNS 5916:2008	Байгаль орчин. Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт Техникийн шаардлага
2	MNS 5918:2023	Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага
3	MNS 5885:2008	Агаар бохирдуулагч бодисын хүлцэх хэм хэмжээ

4	MNS 4585:2016	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
5	MNS 5850:2019	Хөрс бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
6	MNS4943-2011	Усны чанар, хаягдал бохир ус
7	MNS 3342:1982	Байгаль орчны хамгаалал. Усан мандал. Газар доорх усыг бохирдлоос хамгаалах. Ерөнхий шаардлага
8	MNS 0900:2018	Ундны усны эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
9	MNS 3298:1991	Байгаль хамгаалал. Хөрс шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд
10	MNS ISO 226 : 2003	Дуу чимээ – хэвийн норм- түвшний хэмжээ
11	MNS 5342:2007	Автомашины зогсоол, ангилал. ерөнхий шаардлага
12	MNS 0017-0-0-06:1979	Байгаль орчны хамгааллын стандартын систем. Үндсэн дүрэм

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. ТӨСЛИЙН БАЙРШИЛ, ОРЧНЫ ТОЙМ

Манай “Биг могул коул энд энерги” ХХК-ийн “Хөөтийн хонхор”-2 уурхай нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын 2-р багийн нутаг дэвсгэрт нийт 1046.73 га талбайг хамран оршидог.



1.2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АЖ АХУЙ НЭГЖИЙН МЭДЭЭЛЭЛ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн товч мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч	“Биг могул коул энд энерги” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011665117
Регистрийн дугаар:	5369223
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж, Цэнтрүүм барилга, 4 давхар, 401 тоот
Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	MV-020772
Тусгай зөвшөөрөлтэй талбайн хэмжээ	1046.73 га
Ашигт малтмалын төрөл	Чулуун нүүрс
Ашиглалт явуулах хугацаа	9 жил
Төслийн БОННУ-ний тайлантай холбоотой мэдээлэл	БОННУ-ний тайлан боловсруулсан мэргэжлийн байгууллага: “Мэнд шүтээн” ХХК, Тайлан батлагдсан хугацаа: 2024.06.06
Хариуцсан мэргэжилтэнтэй холбогдох мэдээлэл	Байгаль орчны мэргэжилтэн Г.Бадамгарав. Холбогдох утас: 80821128, Майл хаяг: gbadmaa1128@gmail.com

1.3. УУРХАЙН ХҮЧИН ЧАДАЛ, ТЕХНОЛОГИЙН ГОРИМ

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020772 тоот дугаартай “Хөөтийн хонхор”-2 нэртэй ордыг анх 2014 онд ашигт малтмалын нөөцийн улсын бүртгэлд бүртгүүлсэн бөгөөд 2017 оноос олборлолтын үйл ажиллагаа явуулж эхлэсэн. “Хөөтийн хонхор-2” нэртэй нүүрсний ордыг ил уурхайн аргаар ашиглах бөгөөд жилд 1,000 мян.тн нүүрс олборлох хүчин чадалтай байна. Уурхайд олборлолтын ажил хийгдэж байгаа бөгөөд нийт батлагдсан нөөцөөс цэврээр 404.33 мян.тн нүүрсийг олборлосон байна. Уурхайн ашиглалтын 9 жилийн хугацаанд нийт 17.32 сая м3 хөрс хуулж 8.75 сая.тн нүүрс олборлохоор төлөвлөсөн. Хөрс хуулалтын дундаж коэффициент ($K_{хх}$)=2 м3/тн байна.

Ордын нөөц: Ордын 2023 онд хийгдсэн ТЭЗҮ-д тусгаснаар Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2013 оны 12-р сарын 24-ний өдрийн ХХ-24-07 тоот дүгнэлтээр Хөөтийн хонхор- 2 талбай дахь нийт бодитой болон боломжтой (В+С) зэргийн цэвэр нүүрсний нөөцийг 18,191.21 мян.тн-оор, чулууны үетэй нүүрсний нөөцийг 19,869.87 мян. тн-оор, үүнээс эдийн засгийн үр ашигтай бодитой (В) зэргийн цэвэр нөөц 7,189.31 мян.тн-оор, чулууны үетэй нүүрсний нөөцийг 7,835.32 мян.тн-оор, эдийн засгийн үр ашигтай боломжтой (С) зэргийн цэвэр нүүрсний нөөцийг 10,750.26 мян.тн-оор, чулууны үетэй нүүрсний нөөцийг 11,899.34 мян. тн-оор баталжээ. Үүнээс 2021 оны эцсийн тайлангаар үлдэгдэл нөөцийн хэмжээ бодитой (В) зэргээр 6,874.14 мян.тн, боломжтой (С) зэргээр 10,661.11 мян.тн болсон байна.

Орд ашиглалтын технологи: “Хөөтийн хонхор”-2 нүүрсний талбайн нөөцийн нүүрсний давхрааснууд нь газрын гадаргууд харьцангуй ойр тул ил уурхайн аргаар авто тээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системээр олборлоно.

Хүснэгт 2. Ашиглалтын технологийн схем

Ашиглалтын систем	Үндсэн ажил	Технологийн процессууд
Тээвэртэй ашиглалтын технологи	1. Хөрс хуулалт	✚ Өрөмдлөг тэсэлгээ ✚ Ухаж ачих ✚ Тээвэрлэх ✚ Олборлох
	2. Олборлолт	✚ Ухаж ачих ✚ Тээвэрлэх ✚ Овоолох

Хөрс хуулалтын ажил: Хөрсний чулуулгийн хатуулаг нь f=5-7 зэргийн хатуулагтай байгаа ба хатуулаг өндөртэй хэсэгт урьдчилан өрөмдлөг-тэсэлгээний ажлаар сийрэгжүүлсний дараа ухан ачиж, хөрсний гадаад овоолгод шилжүүлэх шаардлагатай. Хөрсний догол нь 5 м-ийн өндөртэй. Ил уурхайн хөрс хуулалтад 3.2 м3 шанаганы багтаамжтай Doosan 800, Doosan 520 болон Hyundai R520LC экскаваторуудыг 60 тн даацтай MT86 маркийн автосамосвалтай хослуулан ажиллуулна.

Шимт хөрс хуулалт: Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.2 метрээс ихгүй (говийн бүс) зузаантайгаар сийрэгжилтийн ажлыг хийлгүйгээр бульдозероор түрж овоолно. Овоолсон шимт хөрсийг утгуурт ачигч автосамосвалын хослолоор уурхайн хүрээ болон овоолгын ирмэгээс урд зүгт 20-30 м-ийн зайд байршуулна. Өрнөлтгүй болсон овоолго, уурхайн бүрэн ашиглагдсан талбайг техникийн нөхөн сэргээлт хийсний дараа шимт хөрсөөр хучна. Ирээдүйд уулын ажилд өртөх талбайн шимт хөрсийг хуулж шууд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн газарт ашиглах боломжтой. Энэ нь шимт хөрсний овоолго хадгалалттай холбоотой зардлыг хэмнэх давуу талтай юм.

Шимт хөрсний овоолго: Шимт хөрсийг 0.2-0.3 м-ийн зузаантайгаар хуулах ба ил уурхайн хойд талд 1.5 км-ийн зайд овоолго үүсгэн хадгалдаг.

Хөрсний гадаад овоолго: Ил уурхайн хөрс хуулалтад автотээвэртэй ашиглалтын систем хэрэглэх бөгөөд ашиглагдсан хоосон орон зайд байнгын уулын ажил явагдах тул хөрсийг гадаад овоолго буюу хөрсний отваль үүсгэж байршуулна. Хоосон чулуулгын овоолгыг ил уурхайн баруун хойно болон зүүн хойд талд өмнөх ашиглалтын жилүүдэд хөрсний овоолго байгуулсан газарт үргэлжлүүлэн байгуулна. Өнгөрсөн хугацаанд хөрс хуулалтын ажлаар овоолгын хэмжээ 4.69 сая м3 болсон байна. Хөрсний овоолгод нэмэгдэж хураагдах хөрсний хэмжээ төслийн хугацаанд 17.5 сая м3, сийрэгжсэн байдлаар 19.7 сая.м3 байхаар тооцоолсон байна. Хөрсний овоолго 30-40 метрийн өндөртэй хөрсний 2 ш, 74 га талбайг эзлэх тул нийт талбайн хэмжээгээр техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийнэ.

Нүүрс олборлолт: Нүүрсний догол нь 5 м-ийн өндөртэй. Hyundai R2900LC маркийн 1.1 м3 шанаганы багтаамжтай экскаватор нүүрсний нимгэн үеүдэд, Hyundai R500LC маркийн 3.2 м3 шанаганы багтаамжтай экскаватор нүүрсний зузаан үеүдэд олборлолт явуулна. Мөн завсрын чулуулгийг ялгах зорилгоор нүүрсний давхарга хоорондын хоосон чулуулгийг экскаватораар хусаж цэвэрлэнэ. Хөрс хуулалтын ажил эхлэхээс өмнө өрөмдлөг-тэсэлгээний аргаар хөрсний 30 хувийг урьдчилан сийрэгжүүлнэ.

Нүүрс олборлолтын үед өрөмдлөг, тэсэлгээний ажлыг мэргэжлийн компанитай гэрээ байгуулан гүйцэтгүүлдэг.

Хүснэгт 3. Уурхайн үндсэн хэмжээсүүд

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1.	Ил уурхайн ажлын доголын өндөр	м	5
2.	Ил уурхайн ажлын бус доголын өндөр	м	10
3.	Ажлын доголын хажуугын өнцөг	град	70 ⁰
4.	Ажлын талбайн өргөн	м	29-45
5.	Траншейн өргөн	м	18
6.	Транцейн налуу	°/00	100
7.	Доголын аюулгүйн тавцангийн өргөн	м	2
8.	Капитал траншейн өргөн	м	18
9.	Уурхайн хажуугийн ерөнхий өнцөг	град	50

Техник, тоног төхөөрөмж: Ил уурхайн олборлолтод олон салаа үетэй нүүрс олборлох тул компанийн ашиглаж буй Hyundai R2900LC маркийн 1.1 м3 шанаганы багтаамжтай экскаваторыг нимгэн нүүрсний үеүд, Hyundai R500LC маркийн 3.2 м3 шанаганы багтаамжтай экскаваторыг нүүрсний зузаан үеүдэд олборлолтын ажил явуулна.

Хүснэгт 4. Уурхайд ашиглаж буй техник

№	Техникууд	Хүчин чадал	Тайлбар
1	Экскаватор, Hyundai R500LC, м3	3.2	Түрээс
2	Экскаватор, Doosan 800, м3	3.2	Түрээс
3	Экскаватор, Doosan 500, м3	3.2	Түрээс
4	Экскаватор, Hyundai R520LC, м3	3.2	Түрээс
5	Экскаватор, Hyundai R2900LC, м3	1.1	Түрээс
6	Экскаватор, Hyundai R3000LC, м3	1.1	Түрээс
7	Автосамосвал, Howo, тн	60	Түрээс
8	Автосамосвал, Hoteo, тн	20	Өөрийн
9	Утгуурт ачигч, Liungong, м3	3	Түрээс
10	Утгуурт ачигч, XCMG, м3	3	Түрээс
11	Бульдозер, Shantui SD16, м3	8.7	Түрээс

Уурхайн зам, тээвэр.

Гадаад тээврийн зам: “Хөөтийн хонхор-2” нэртэй нүүрсний уурхайгаас Чойрын өртөө хүртэл 130 км зайтай. Тус 130 км автозамыг аж ахуй нэгжүүд хуваан авч сайжруулсан шороон замыг барьсан бөгөөд байнгын арчилгаа, засварын ажлын гүйцэтгэж байна. Мөн тухайн нүүрс тээвэрлэгч аж ахуй нэгжүүд 1 автомашинаас 15,000 төгрөгийн хураамжийг улсын төсөвт төлдөг.

Дотоод тээврийн зам: Ил уурхайн хөрс тээвэрлэлтэд БНХАУ-ын 60 тн даацтай МТ86 маркийн автосамосвал, нүүрсний тээвэрлэлтэд 20 тн даацтай Howo маркийн автосамосвал ажиллуулдаг. Ил уурхайгаас олборлосон нүүрсийг автосамосвалаар тээвэрлэн ил уурхайгаас баруун хойд зүгт байрлах нүүрсний агуулахад буулгах ба нүүрс тээвэрлэлтийн хамгийн их зай хамгийн 2 км байна. Хөрсийг ил уурхайн хойд, зүүн урд талд байрлах хөрсний гадаад овоолгод тээвэрлэн овоолох ба хөрс тээвэрлэлтийн хамгийн их зай 2 км байна. Тээвэрлэлтийн үед үүсэх тоосыг зам усалгааны машинаар дарна. Ил уурхайн дотоод тээврийн болон уурхайн гаднах тээврийн замын цэвэрлэгээ, засварын ажилд автогрейдер, зам усалгааны машинуудыг хэрэглэнэ. Автосамосвалуудын хоорондын зай 30 м байх үед аюулгүй ажиллах бүрэн боломжтой юм.

Хүснэгт 5. Ил уурхайн автозамын үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хөрс тээвэр	Нүүрс тээвэр
1	Автосамосвалын марк		МТ86	Howo 20
2	Автосамосвалын дундаж хурд	км/ц	25	25
3	Эргэлтийн радиус	м	15	15
4	Авто замын зурвасын тоо	ш	2	2
5	Автосамосвалын өргөн	м	4.39	2.5
6	Автосамосвалын урт	м	8.67	7.74
7	Хамгаалалтын зурвасын өргөн	м	2	2
8	Автосамосвалууд зөрөх үеийн аюулгүйн зай	м	2	2
9	Замын хөдөлгөөний зурвасын өргөн	м	14	10
10	Дугуйн хажуугийн гулсалтыг тооцох коэффициент	-	0.16	0.16
11	Замын хөндлөн налуу	-	0.003	0.003
12	Замын муруйлтын зөвшөөрөгдөх бага радиус	м	30	30
13	Замын тойруу хэсэг дэх хөдөлгөөний зурвасын өргөсөлт	м	2.5	2.5
14	Сонгож авсан замын өргөн (уурхай дотор)	м	16	16
15	Сонгож авсан замын өргөн (уурхайгаас бусад)	м	16	16

1.4. Уурхайн 2026 оны уулын ажлын төлөвлөгөө

Хөөтийн хонхор-2 уурхайн 2026 оны Уулын ажлын төлөвлөгөөнд тусгаснаар төлөвлөгөөт онд уурхай нь 3409.6 мян.м³ хөрс хуулалтын ажил гүйцэтгэх бөгөөд 1000.0 мян.тн нүүрс олборлоно. /УАТ Хуу.13/

Ажиллах хугацаа. Уурхай нь нийтийн баяр ёслолын өдрүүд, цаг агаарын саатал болон засвар үйлчилгээ хийх өдрүүдээс бусад үед жилийн дөрвөн улирал тасралтгүй, хоногт 2 ээлжээр, ээлжинд 12 цагаар ажиллана.

Хүснэгт 6. Уурхайн 2026 оны Уулын ажлын төлөвлөгөөнд тооцсон ажиллах горим

№	Үзүүлэлтүүд	Утга
1.	Жилийн календарчилсан хоногийн тоо	365
2.	Уурхайн амрах хоног	15
3.	Засвар үйлчилгээ, цаг агаарын саатал	24
4.	Уурхайн жилд ажиллах хоног	326
5.	Ээлжийн тоо	2
6.	Ээлжийн үргэлжлэх хугацаа	12
7.	Жилд ажиллах цаг	7,824

1.5. ДЭД БҮТЭЦ

Зам харилцаа.

Хөөтийн хонхор-2 төслийн талбай нь Улаанбаатар хотоос зүүн-урагш 340 км-т Баянжаргалан сумын нутагт орших бөгөөд Дундговь аймгийн Мандалговь хотоос зүүн урагш 130 км, Баянжаргалан сумаас баруун зүгт 25 км-т байрлана. Уурхайн талбайд жилийн аль ч улирал Баянжаргалан сум юм уу аймгийн төв Мандалговь хотоос шороон замаар очих боломжтой.

Цахилгаан хангамж.

“Хөөтийн хонхор-2” уурхайн ойролцоо “МАК” ХХК-ийн татсан 35/10 кВ-ын өндөр хүчдэлийн шугамд холбогдсон байдаг. Уурхайн цахилгааны хэрэглээг “МАК” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу хангадаг.

Усан хангамж.

Уурхайн ашиглалтын үед унд ахуйн усны хэрэгцээг тусгай зөвшөөрлийн талбайд гаргасан 1.1 л/с ундаргатай гүний худгаас хангана. Зам талбайн усалгаа болон ногоон байгууламжийн усалгааг уурхайн карьерт орж ирэх шүүрлийн усаар хангана.

Уурхайн баруунд урд хэсэгт 25 орчим гүнээс газрын доорх ус шүүрч уурхайн олборлолтыг зогсоож, карьерын зүүн талын мөргөцгөөс олборлолт явуулж байгаа бөгөөд олборлолтын явцад үүссэн шүүрлийн усыг зумпын аргаар соруулж уурхайн карьераас 2.5 км зайд байгальд задгай байдлаар шингээж байна.

Унд ахуйн хэрэглээний үс ашиглалт.

Унд ахуйн усны хэрэглээг БОНХАЖЯ-ны сайдын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/301 дугаар тушаалаар баталсан нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны нормын 12 дугаар хавсралтыг үндэслэж тооцов.

Хүснэгт 7. 2024 онд унд ахуйн хэрэглээнд ашигласан усны тооцоо

Нийт ажилчдын тоо	Нэг хүний хоногт ашиглах усны норм, л	Жилд ажиллах хоног	Нийт ашиглах усны хэмжээ, м ³
145	150	326	7,090.5

Уурхайн бүс орчмын газрын гүний ус нь эрдэсжилт болон хатуулаг өндөртэй байдаг тул унд ахуйн хэрэглээнд зөөлрүүлэн ашигладаг.



Ногоон байгууламжын усалгаа.

“Тэр бум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2026 оны 05-р сард уурхайн кемпийн гадна нийт 500 ширхэг хайлаас мод суулгацаар шуудуулан тарихаар төлөвлөсөн.

2023-2025 оны хооронд уурхайн кемпийн гадна нийт 900 ширхэг хайлаас мод, 600 ширхэг Шар хуайс мод тарьсан.

Ногоон байгууламжийн усалгаанд ашигласан усны хэрэглээг Монгол улсын Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын А/301 дугаартай тушаалын хавсралтаар баталсан Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны нормд заасан 1 ш суулгац усах усны норм /40 л/-оор тооцлоо.

Хүснэгт 8. Ногоон байгууламжын усалгаанд ашигласан усны хэрэглээ

Суулгацын тоо, ш	1 ш суулгац усах норм, л	Усалгаа хийх хоногийн тоо	Нийт ашиглах усны хэмжээ, м3
2000	40	32	2,560 м3

Зам талбайн тоосжилт дарахад ашигласан усны хэмжээ.

Уурхайн зам талбайн тоосжилтыг дарахад 20 тн-ийн багтаамжтай усны машин ашигладаг. Зам усалгааны ажилд шаардагдах усны хэрэгцээг шүүрлийн уснаас хангах тул уурхай ажиллах хугацаанд хавар 4-р сараас 12-р сар хүртэл өдөр бүр хийнэ.

Хүснэгт 6. Зам талбайн тоосжилт дарахад ашигласан усны хэмжээ

Замын урт	1 м2 зам усахад шаардагдах усны норм, л	Усалгаа хийх давтамж	Зам усалгаа хийх хоног	Нийт ашиглах усны хэмжээ, м3
12,000 м2	2	4	206	19,776

Уурхайн үйл ажиллагаанаас гарах хаягдал ус

Ахуйн хэрэглээний бохир ус. Ахуйн бохир усыг цооногт хуримтлуулж, соруулах байдлаар шийдсэн.

2024 онд уурхайн кемпийн гадна ашиглаж байсан хөрсний бохирдол үүсгэж буй нүхэн жорлонг булж эко нойл байгуулсан.

Эко 00-ийг байгуулахдаа бохир цуглуулах 25 тн-ийн багтаамжтай төмөр танк суурилуулсан бөгөөд Дундговь Ус ОНӨААТҮГ-тай бохир ус соруулах гэрээг байгуулан

ажиллаж байна.



Зураг 1.Бохир хуримтлуулах 25 тн багтаамжтай танк суурилуулсан байдал.


БҮЛЭГ 2. АШИГЛАЛТЫН ТАЛБАЙ ОРЧМЫН БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ХУРААНГУЙ

2.1. Талбайн газарзүйн байршил.

Ашигт малтмал ашиглалтын MV-020772 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хөөтийн хонхор-2” нэртэй нүүрсний орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын Энгэр-Ус багийн нутагт нийт 1046.73 га талбайг хамран Говь-Угтаал, Гурвансайхан, Баянжаргалан сумдын нутгийн заагт баруун талаараа Баруун хүрийн ухаа, зүүн талаараа Талын хоолой, Талын худгийн хөндий, хойд талаараа Хар хадны толгодоор оршдог.

Орд орчмын район нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Говийн их муж, Дорнод говийн муж, Умард говийн ухаа толгодот талын тойрогт хамаарах бөгөөд байгалийн бүс бүслүүрийн хувьд цөлөрхөг хээрийн бүсэд багтаж байна.

Сав газрын ангиллаар Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарт харъяалагдана.



Зураг 2. “Хөөтийн хонхор”-2 нэртэй нүүрсний ордын байршилын зураг

2.2. Цаг уур амьсгалын үндсэн үзүүлэлтүүд

Хөөтийн хонхор-2 нүүрсний талбай нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, улирал хоорондын температурын хэлбэлзэл ихтэй бүс нутагт байрладаг.

Ойролцоох Гурвансайхан сумын цаг уурын станцын 2023 оны 2-р сараас 2024 оны 8-р сарын хоорондох хэмжилтээр сарын агаарын дундаж температур хамгийн хүйтэн сард -16.6°C , хамгийн дулаан сард 22.5°C байсан нь уур амьсгалын улирлын огцом өөрчлөлтийг харуулж байна. Жилийн агаарын дундаж температур 5.5°C байна.

Улирлын шилжилт хурдан явагддаг, хавраас зун руу богино хугацаанд огцом дулаарч, зуны сүүлээс намар, өвөл рүү эрчимтэй сэрүүсч байна.

Улирлын онцлогууд:

- Өвөл (12-р сар – 2-р сар):** Хүйтний эрч хамгийн их үедээ хүрсэн нь 1-р сард -16.6°C , 12-р сард -15.8°C , 2-р сард бага зэрэг дулаарсан ч -12.3°C хэвээр байсан нь хүйтэн улирал үргэлжилсээр байсныг харуулж байна.
- Хавар (3-р сар – 5-р сар):** 3-р сард -0.9°C байгаа нь хүйтэн уур амьсгалтай хаврын эхлэлийг илтгэж байна, 4-р сараас температур нэмэгдэж (6.4°C), 5-р сар гэхэд 15°C хүрч уур амьсгал дулаарсан байна.
- Зун (6-р сар – 8-р сар):** 6-р сард 21.4°C , 7-р сард хамгийн дулаан үе болох 22.5°C , 8-р сард 21°C . Энэ нь зун бага зэргийн хэлбэлзэлтэй, тогтвортой дулаан байсныг илтгэж байна.
- Намар (9-р сар – 11-р сар):** 9-р сард 15.3°C байсан бол 10-р сард 7.7°C болж огцом сэрүүссэн байна. 11-р сард температур -7.4°C болж, өвлийн уур амьсгал мэдэгдэхүйц эхэлжээ.

Хүснэгт 9. Сарын агаарын дундаж температур

Сарууд	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Агаарын дундаж темератур, $^{\circ}\text{C}$	-16.6	-12.3	-0.9	6.4	15	21.4	22.5	21	15.3	7.7	-7.4	-15.8



Хур тунадас. Дундговь аймгийн хэмжээнд жилийн нийлбэр хур тунадасны хэмжээ 240.3 мм, жилийн хамгийн их хур тунадас ихэнхдээ зуны улиралд буюу температур хамгийн өндөр үед ордог. 2023, 2024 онуудад жилийн хамгийн их хур тунадас зун 7-р сард (85.35 мм) орсон байна. Өвөл, хавар, намрын эхэн үед агаар хуурай, хур тунадас багатай. Хамгийн хуурай үед нь хавар 2-р сард буюу хур тунадасны хэмжээ 0.80 мм байна.


Хүснэгт 10. 2023, 2024 оны сарын нийлбэр хур тунадасны хэмжээ

Сарууд	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Сарын нийлбэр хур тунадас, мм	2.05	0.80	2.10	2.40	35.65	18.05	85.35	55.15	21.45	9.25	2.55	5.45

Салхины үнэмлэхүй хурд. Аймгийн хэмжээнд 2023, 2024 оны мэдээнээс үзэхэд сарын салхины үнэмлэхүй хурд 14-34 м/с хооронд хэлбэлзсэн , хавар 3 болон 4-р сард салхины үнэмлэхүй хурд хамгийн өндөр (26...34 м/с) байна. Салхины үнэмлэхүй хурд олон сарын турш 20 м/с-ээс давсан нь тухайн бүс нутагт улирлын чанартай хүчтэй салхи байнга тохиолддог, салхины эрчим өндөр болохыг харуулж байна.

Хүснэгт 11. Сарын салхины үнэмлэхүй хурд, м/с

Сарууд	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2023	22	17	34	26	27	24	28	26	22	14	15	27
2024	17	16	28	29	24	26	23	18	15	23	25	15
Дундаж	19.5	16.5	31	27.5	25.5	25	25.5	22	18.5	18.5	20	21



Нийт шороон шуургатай өдрүүдийн ихэнх нь хаврын улиралд (3-5-р сар) тохиолдсон байна. Хавар 4-р сард салхины эрчим өндөр, хамгийн их шороон шуургатай өдрүүд бүртгэгдсэн байна. Намар, өвлийн эхэн үед салхины эрч сул боловч тохиолдлын шинжтэй шуурга гарсан байна.

Өвлийн улиралд 11, 12, 1-р саруудад цасан шуургатай өдөр хамгийн их тохиолддог, тус саруудад салхины эрчим 15-27 м/с хооронд хэлбэлздэг. 2023 онд цасан шуургатай өдөр өвөл 12-р сард хамгийн их буюу 7 удаа, 2024 онд цасан шуургатай өдөр өвөл 1-р сард 8 удаа бүртгэгдсэн байна.

Хүснэгт 12.

Шороон шуургатай өдрийн тоо, м/с

Он, сар	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2023	1	1	3	11	6						1	
2024			1	2	2	0			1	1		

Цасан шуургатай өдрийн тоо, м/с

Он, сар	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2023	1			2							5	7
2024	8	2		1						2	3	6

2.3. Хөрсөн бүрхэвч.

Тус талбай нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалтаар цайвар хүрэн хөрсний дэд бүс Баяндэлгэрийн 8-р тойрогт багтана. Эндхийн ургамалшил тачир сийрэг зарим газраа ургамалгүй цулгуй байдаг учраас салхины үйлчлэлд хялбар өртөж хөрсний өнгөн хэсэг салхинд хийсч эвдрэх үйл явц элсэнцэр хөрстэй газраар байнга ажиглагдана. Цайвар хүрэн хөрсний гадарга дээр хөдөлгөөнтэй хэмхдэс сайр чулуу ихтэй, өнгөн хөрс их хуурайшилттай, хөрсний дээд давхарга элсэнцэр бүрэлдэхүүнтэй. Хөрс шим тэжээлийн бодисын хангамжаар бага, хөрсний үржил шимт чанар дунд зэрэг, механик бүрэлдэхүүнээр өнгөн давхарга нь элсэнцэр, элсэрхэг бүрэлдэхүүнтэй байгаагаар онцлогтой байна.

“Хөөтийн хонхор”-2 нэртэй нүүрсний ордыг ашиглах төлсийн 2024 онд хийгдсэн БОННУ-ний нэмэлт тодотголын ажлын хүрээнд хийсэн хөрсний морфлогийн бичиглэлийн үр дүнгээс үзэхэд ашиглалтын талбай орчимд цайвар хүрэн хөрс, хүрэн хөрс зонхилох бөгөөд хөрсний дундаж зузаан нь 10-20 см байна.

2.4. Ургамлан нөмрөг.

Монгол орны ургамал газарзүйн тойргоор энэ бүс нутаг нь Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.). Энэ тойрогт 793 зүйл ургамалтай бөгөөд зөвхөн энэ тойрогт ургадаг 1 зүйл (*Paraver rubro-aurantiacum*)ийн ургамалтай. Дундад Халхын тойргийн үндсэн төрхийг үзүүлэх зүйлүүд: Жижигнавчит харгана (*Caragana microphylla*), Япон хайлаас (*Ulmus pumila*), Бариулт бүйлэс (*Amygdalus pedunculata*), Дэрэвгэр тарна (*Polygonum divaricatum*), Дорнодын хамхуул (*Corispermum orientale*), Дэрвээн цульхир (*Agriophyllum pungens*), Монгол хамхуул (*Corispermum mongolicum*), Услиг мананхамхаг (*Bassia dasyphylla*), Козловын сүүт-өвс (*Euphorbia kozlovii*), Сибирь шорной (*Atriplex sibirica*), Эрлийз лууль (*Chenopodium hybridum*), Клеменцийн ортууз (*Oxytropis klementzii*), Хангайн шарилж (*Artemisia changaica*), Толгодын багваахай (*Taraxacum collinum*) зэрэг болно.

2.5. Амьтны аймаг.

“Хөөтийн хонхор-2” нүүрсний ордын бүс нутаг нь Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлалаар Монгол-Төвдийн муж, Монгол дагуурын хээрийн дэд муж, Монгол дагуурын хээрийн тойргийн урд зах, Дорноговийн хээрийн тойргийн хойд захад хамаарна.

2.6. Усан орчны төлөв байдал.

Гадаргын усны төлөв байдал. Энэ бүс нутаг ус зүйн хувьд газар доорх усны нөөц зонхилсон “Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газар”-т хамаарна.

Умард говийн усны сав газар нь 8 аймаг, 59 сум, Нийслэлийн Багахангай дүүргийн газар нутгийг хамарсан нийт 180404.2 км² талбай бүхий говь, хээрийн бүсүүдийг хамарсан өргөн уудам нутаг юм. Умард говийн усны сав газар нь Монгол орны төв ба дундад халхын тал, өмнөд болон зүүн өмнөд говийн бүсийн хур тунадас багатай нутаг дэвсгэрт хамаарагддаг бөгөөд Дундговь аймгийн 92.7 хувь нь тус сав газарт харъяалагдана. Газрын гадаргын хувьд баруун хагас нь уулархаг бөгөөд нутгийн ихэнх хэсэг ухаа гүвээт тал, цав толгод, хотгор нам газар болно. Энэ бүс нутагт гадаргын ус нэн ховор. Сав газрын баруун хойд хэсгээр (Өвөрхангай аймаг) Төв Азийн гадагш урсгалгүй ай савд хамрагдах гол цөөн тоотой бий. Харин говийн бүсэд түр зуурын уруйн ус урсах хуурай сайрууд маш түгээмэл ажиглагддаг. [<https://water.gov.mn/savgazar/113>]

“Хөөтийн хонхор”-2 уурхайн ойр орчимд хамгийн ойр орших гадаргын ус нь Хөөтийн булаг бөгөөд жилийн дөрвөн улиралд устай байх боловч цаг уур хуурайших тутамд ус нь татарч багассаар хатдаг байна.

Талбайн гидрогеологийн нөхцөл. “Хөөтийн хонхор”-2 ордыг ашиглах төслийн ТЭЗҮ-ийн тайлангын нэмэлт тодотголын ажлыг 2023 онд “МАЙНДАТА” ХХК-аар гүйцэтгүүлсэн.

ТЭЗҮ-ийн нэмэлт тодотголын ажлын хүрээнд уурхайн ашиглалтын талбай орчмын гидрогеологийн үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлох зорилгоор “Хөөтийн хонхор”-2 талбайн хайгуулын ажлын үед гидрогеологийн судалгааны зориулалтаар өрөмдсөн Н-1, Н-2, Н-3, Н-2А цооногуудад гидрогеологийн ажиглалт хийх мөн цооногуудад усны түвшин хэмжих, тус талбайд тархсан газрын доорх усыг илрүүлэх, байршлыг тогтоох, газрын доорх усны тархалт, хуримтлал, түүний хөдөлгөөн, чиглэл, хил хязгаарын нөхцөлийг тогтоох ажлуудыг гүйцэтгэсэн байна.

Ингэхдээ хээрийн ажлын явцад өрөмдсөн гидрогеологийн цооногуудад каротажийн судалгаа явуулж үр дүнг өрөмдлөгийн үеийн гидрогеологийн ажиглалт, туршилтын ажлын үр дүнтэй харьцуулан уст үеийн байршил, зузааныг тогтоосон болно. Үр дүнг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 13. Гидрогеологийн үндсэн үзүүлэлтүүд

Цооног дугаар	Ус илэрсэн гүн, м	Тогтоосон түвшин, м	Уст үеийн зузаан, м	Ус агуулагч чулуулгийн тодорхойлолт
Н-1	10.0	10.0	38.0	Элсэн чулуу, гравелитын салаавчилсан үе
Н-2	12.0	7.0	34.4	Элсэн чулуу, аргиллит, нүүрс, салаавчилсан үе
Н-3	12.0	11.0	-	Нурсан, гүн-27.0 м
Н-2А	12.7	7.0	34.4	Элсэн чулуу, аргиллит, салаавчисан үе

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Хөөтийн хонхор”-2 нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн “БОННУ-ний нэмэлт тодотголын тайлан”-нд тодорхойлсноор төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм эдийн засагт дараах эерэг болон сөрөг нөлөөг үзүүлэхээр байна.

3.1. Агаарын чанарт учруулах сөрөг нөлөөлөл

Тоосны бохирдол.

- Уурхайн тээрэлэлтийн явцад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс шалтгаалан гадаад болон дотоод тээврийн замаас тоосжилт үүснэ,
- Ашигт малтмал олборлолтын явцад тэсэлгээгээр суларсан хөрснөөс тоосжилт үүснэ ,
- Хөрсний овоолго үүсгэх үед автомеханизм болох утгуурт ачигчийн үйл ажиллагаагаар орчны агаарт тоос, тоосонцор ялгарна.

Хорт хийн бохирдол.

Уурхайд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс ялгарах угаарын хий (CO), азотын дутуу исэл (N₂O), хүхэрлэг хий (SO₂) зэрэг хорт хий нь тухайн орчны агаарын чанарт нөлөөлнө.

3.2. Газрын гадарга болон хөрсөн бүрхэвчид учруулах сөрөг нөлөөлөл

Газрын эвдрэл.

Уурхайн ашигт малтмал олборлох малталтын талбай, хөрсний овоолго үүсгэх хэсэг, гадаад болон дотоод тээврийн зам, уурхайн барилга байгууламж зэргийг барьж байгуулах, ашиглах явцад газрын гадарга, хөрсөн бүрхэвч эвдэрч байгалийн унаган төрхөө алдана. Төсөл хэрэгжих 9 жилийн хугацаанд 17.32 сая м³ хөрс хуулж 8.75 сая.тн нүүрс олборлоно. Өнөөгийн байдлаар уурхайн ухааш 25 м гүн байгаа бөгөөд ашиглалтын хугацаанд нийт олборлолтод өртсөн нийт талбайн хэмжээ 68.23 га байна.

3.3. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Уурхайн үйл ажиллагааны явцад карьер болон овоолгууд, дэд бүтцийн барилга байгууламжуудыг барих, ашиглах үед тухайн орчны ургамлан бүрхэвч хөрстэй цуг хуулагдан устана. Мөн замын тоос, шороо, авто машины хөдөлгүүрээс ялгарах хорт хий зэргээр эргэн тойрны ургамлан нөмрөг дарагдах, бохирдох, тухайн орчны ургамлын өсөлт удаашрах, төрөл зүйлийн тоо буурах, өөрчлөгдөх эрсдэлтэй.

3.4. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөлөл

Тухайн бүс нутгийн хөхтөн амьтдын тархац нутаг хумигдах, тоо толгой буурах, хүн, машин техникийн хөдөлгөөн, дуу чимээ, гэрэл зэргээс амьтад дайжих г.м амьтны аймагт шууд биш ч дам байдлаар сөрөг нөлөө үзүүлнэ.

3.5. Газрын гадарга болон гүний усанд учруулах сөрөг нөлөөлөл

Төсөл хэрэгжих талбайн ойр орчинд ил урсацтай булаг шанд байхгүй ба Хөөтийн булаг нь уурхайн талбайгаас 1.8 км зайд оршино.

Уурхайн үйл ажиллагааны үед хог хаягдал ил задгай хаях, шатах тослох материал алдагдах зэргээс үүдэн газар доорх ус болон булгийн усыг бохирдуулж болзошгүй байна.

Төслийн унд ахуйн ус хэрэглээг уурхайн талбайд байрлах 1.1 л/с-н ундаргатай гүний худгийн уснаас, уурхайн өрөмдлөгийн ажлын усны хэрэглээг уурхайн шүүрлийн уснаас хангана.

“Хөөтийн хонхор”-2 ордын гидрогеологийн нарийвчилсан судалгаагаар уурхайн олборлолтын явцад хоногт 87.264 м³ шүүрлийн ус үүсэх бөгөөд жилд 31,937.50 м³ ус соруулахаар байна. 2025 онд ашиглах усны дүгнэлтээр унд ахуйн хэрэглээнд 7,938.75 м³ зам талбайн тоосжилт дарахад 7500 м³, ногоон байгууламжын усалгаанд 900 м³ ус буюу нийт 16,338.75 м³ ус ашиглахаар тооцсон. Иймд уурхайн үйл ажиллагаанаас гүний усны нөөцөд бага зэрэг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

3.6. Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдал орчны эрүүл ахуйд сөргөөр нөлөөлөх.

Төслийн үйл ажиллагаанаас дараах хог хаягдлууд үүснэ.

Хүснэгт 14. Үүсэх хог хаягдлын төрөл

Үүсэх хог хаягдлын төрөл	Хог хаягдлын ангиллаар
Ахуйн хэрэглээний хатуу хог хаягдал	Энгийн хог хаягдал
Ахуйн хэрэглээний шингэн хог хаягдал	Энгийн хог хаягдал
Засварын талбайгаас үүсэх хатуу хог хаягдал	Барилгын материалын хаягдал
Үнсний хаягдал	Энгийн хог хаягдал
Ашигласан тос тосолгооны материалын хаягдал	Аюултай хог хаягдал

- Хог хаягдлыг ил задгай хаях,
- Шаардлага хангаагүй хогийн саванд хадгалах,
- Дулааны улиралд хог хаягдлыг хэт удаан хадгалах,
- Засварын талбайд үүсэх төмрийн хаягдлыг төвлөрсөн нэг цэгт байрлуухгүй байх,
- Ашигласан тос тосолгооны материал хөрсөнд асгарч алдагдсан тохиолдолд хариу арга хэмжээ авахгүй байх,
- Ахуйн хэрэглээнээс үүссэн шингэн хог хаягдлыг ил асгах, хөрсөнд нэвчүүлэн зайлуулах нь орчны агаар, хөрсний шимт чанар, Хөөтийн булгын усны чанар, урсац зэрэгт сөргөөр нөлөөлнө.

3.7. Нийгэм эдийн засагт учруулах эерэг болон сөрөг нөлөөлөл

- Уурхайн үйл ажиллагааны туршид Баянжаргалан сумын иргэд болон нөлөөллийн бүсийн иргэдийн амьдралын хэв маяг, эрүүл мэндэд шууд болон дам байдлаар эерэг болон сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.
- Төслийн үйл ажиллагаанаас улс болон орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх, ажлын байр бий болох, ядуурлыг бууруулах зэргээр нийгэм эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ. Төсөл хэрэгжсэнээр жил тутам 7.4-10.6 тэрбум төгрөг, нийт ашиглалтын хугацаанд 84.14 тэрбум төгрөгийг төрөл бүрийн хэлбэрээр улсын болон орон нутгийн төсөвт оруулж байгаа нь нийт борлуулалтын орлогын 21.4%-тай тэнцэхээр байна. Төслийн хугацаанд улсын төсөвт 46.0 тэрбум төгрөг, орон нутагт 38.15 тэрбум төгрөг оруулна.

БҮЛЭГ 4. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төслийн талбайн орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

БОАЖЯ нь төслийн БОМТ-г батлан төсөл хэрэгжүүлэх зөвшөөрлийг олгох, жил бүрийн хэрэгжилтийн тайланг хянаж дараа жилийн төлөвлөгөөг батлах замаар уг төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянана. Мөн БОМТ-ний хэрэгжилтэд сумын байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, Засаг дарга, БОАЖЯ болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих эрхтэй.

БОМТ нь доорх үндсэн 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

-  Төслийн шууд ба шууд бус сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах үйл ажиллагааг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө,
-  Төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ хэрхэн үр дүнтэй болсон эсэх, шаардлагатай үед нэмэлт арга хэмжээ авах зорилгоор төслийн үргэлжлэх бүх л хугацааны турш хэрэгжүүлэх орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Төслийн 2025 оны БОМТ-ний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхдөө дараах баримт бичигт үндэслэв. Үүнд:

- 2024 онд батлагдсан БОННУ-ний нэмэлт тодотголын тайлангийн БОХТ-ний хэсэгт 2026 онд хийхээр тусгасан арга хэмжээнүүд,
- 2026 онд хэрэгжүүлэх уулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулж,
- Төслийн үйл ажиллагаанд хийсэн байгаль орчны аудитын тайлангийн дүгнэлт зөвлөмж,
- Орон нутгаас өгсөн санал зөвлөмжүүдийг нэмэлтээр тусган боловсруулав.

2025 оны БОМТ-ний биелэлтийг орон нутгаас томилогдсон ажлын комисс 2025 оны 12-р сарын 11-ны өдөр 90.3 хувийн үнэлгээтэйгээр дүгнэсэн бөгөөд ажлын хэсгээс дараах саналуудыг гаргав.

Хүснэгт 15. Орон нутгаас өгсөн санал

№	Орон нутгаас өгсөн санал	Саналын хүрээнд хэрэгжүүлэхээр тусгасан ажлууд
1.	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан бохирдлын үзүүлэлт тодорхойлох үедээ нөлөөллийн бүсийн иргэд, орон нутгийн төлөөллийг байлцуулан хэмжилтийг хийх, гарсан бохирдлыг бууруулах арга хэмжээг төлөвлөх.	2026 онд орчны хяналт шинжилгээг зохион байгуулах явцад тус арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
2.	“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн, “Дундговьго ногооруулья” дэд хөтөлбөрийн хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх талаар сум орон нутгийн байгууллагатай зөвшилцөн төлөвлөж, ургалтын хувьд анхаарах	2025 онд 3 жилийн хугацаатай хэрэгжүүлэх “Орон нутагт мод тарих” төслийг боловсруулж орон нутгийн засхиргааны нэгжид танилцуулсан. 2026 онд тус төслийн эхний жилд хийгдэх ажлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.
3.	Шүүрлийн усыг орон нутгийн захиргаа, нөлөөллийн бүсийн иргэдийн саналыг харгалзан дахин ашиглах байдлаар шийдвэрлэх.	Уурхайн шүүрлийн усыг ашиглан ойр орчмыг айл өрхийн мал, зэрлэг ан амьтад ундаалах хөв цөөрөм байгуулахаар 2026 онд хэрэгжүүлэх усан орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаж оруулав.
4.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд “Аргын хад” орон нутгийн тусгай хамгаалалттай газарт зэрлэг ан амьтан ундаалах зорилгоор хөв цөөрөм байгуулах	Хөв цөөрөм байгуулах боломжит нөхцлийг судлахаар төлөвлөв.
5.	Нөлөөллийн бүсийн иргэдэд үйл ажиллагааг танилцуулж, санал хүсэлтийг хүлээн авч ажиллах (шүүрлийн усаар мал, амьтан услах усан сан байгуулах санал гарсан).	Усан орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаж оруулав.
6.	Усны чанарын шинжилгээг улирал тутам хийхээр төлөвлөж, хэрэгжүүлэх	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт тухайн жил нийт 3 удаа шинжилгээ хийхээр тусгав.

“ХӨӨТИЙН ХОНХОР-2” УУРХАЙН 2025 ОНЫ ОРЧНЫ БОХИРДЛЫН
СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

2025 онд 4 болон 9-р сард Орчны хяналт-шинжилгээг Дундговь аймгийн Ус Цаг Уурыг газартай хамтран гүйцэтгэсэн. 10-р сард уурхайн хөрс, усны хяналтын цэгүүдээс дээж аван шинжилгээг “Инженер геодези” ХХК-ийн Хөрс судлалын лабораториор хийлгэсэн.

Шинжилгээний үр дүнгээс үзэхэд холбогдох стандартаас хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна.

I. Агаарын чанарын судалгаа, шинжилгээний үр дүн.

Сорьц авсан цэг	SO2 мг/м3		NO2 мг/м3		Нийт тоос, мкг/м3	
	19/05/2025	08/09/2025	19/05/2025	08/09/2025	19/05/2025	08/09/2025
карьер дээр (A2)	0.011	0.016	0.022	0.034	0.046	0.081

Ажилчдын байр орчим (A5)	0.014	0.017	0.028	0.037	0.031	0.46
Засвар үйлчилгээний төв (A1)	0.016	0.012	0.031	0.032	0.045	0.79
Технологийн зам	0.017	0.017	0.035	0.025	0.041	0.077
Нүүрс буулгах талбай (A3)	0.018	0.013	0.033	0.039	0.051	0.064
4585:2016 стандарт хүлцэх хэмжээ	0.45		0.2		0.5	




График 1. SO₂ агууламжын хэмжээ (мг/м³)




График 2. NO₂ агууламжын хэмжээ (мг/м³)




График 3. Нийт тоосны концентраци, мг/м³

II. Хөрсний чанарын хяналт-шинжилгээний үр дүн




График 4. Хөрсний РН орчин




График 5. Ялзмагын агууламж, %




График 6. Хөрсөнд агуулагдаж буй хөдөлгөөнт фосфорын хэмжээ, мг/кг

III. Усны чанарын хяналт-шинжилгээний үр дүн.

Хүснэгт 16- Усны химийн завлан шинжилгээний үр дүн

Тодорхойлсон үзүүлэлтүүд	Сорьц авсан цэгүүд		MNS4586:1998	MNS0900:2018
	Шүүрлийн ус	Унд ахуйн худгийн ус	Хүлцэх агууламж мг/л	Хүлцэх агууламж мг/л
Жинлэгдэх бодис, Ж/Б мг/л	35.2	6.8	-	-
Перманганатын исэлдэх чанар, Пич мг/л	8.53	5.06	10	
Кальцийн ион(Ca ²⁺) мг/л	23.1	62.5	100	100.0
Магнийн ион (Mg ²⁺)мг/л	11.70	7.02	30	30.0
Аммоний ион (NH ₄) мг/л	0.48	0.17	1.5	1.5
Нийт төмөр (Fe) мг/л	0.10	0.02	0.3	0.3
Хлорийн ион (Cl) мг/л	15.7	7.2	350	350
Сульфатын ион (SO ₄ ²⁻)мг/л	9.8	37.5	100	500
Нитритийн ион (NO ₂) мг/л	0.043	0.002	1.0	1.0
Нитратийн ион (NO ₃)мг/л	2.82	2.38	50	50.0
Фосфатын ион	0.077	0.028	3.5	3.5

(PO ₄ ³⁻) мг/л				
Фтор (F ⁻) мг/л	1.32	0.97	-	0.7-1.5
Хатуулаг мг-экв/л	2.12	3.70	7	7.0
Натри Кали (Na+K мг/л)	25.19	120.19	-	-
ЦДЧ	291.6	729	-	1000
Гидрокарбонат(HCO ₃) мг/л	25.19	458.7	-	-
Эрдэжилт мг/л	236.7	693.1	-	-
Урвалын орчин (pH)	9.07	8.15	-	6.5-8.5

Шинжилгээний үр дүнгээр:

Шүүрлийн ус. Уралын орчин сул шүлтлэг, 3-р төрлийн, чанарын хувьд цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй, зөөлөн ус байна. Шинжилсэн үзүүлэлтүүд MNS4586:1998 стандартад заасан хүлцэх хэмжээнээс хэтрээгүй байна.

Унд ахуйн хэрэгцээнд ашигладаг худгийн ус. Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, I төрлийн чанарын хувьд зөөлөвтөр, цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй ус байна. Шинжилсэн үзүүлэлтүүдээс “Унд ахуйн усны чанар” MNS 0900:2018 стандартад заасан хүлцэх хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна.

2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ХЭРЭГЖҮҮЛЭХ НИЙТ ЗАРДАЛ

2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) хэрэгжүүлэх нийт зардалд 32,043,000 [гучин хоёр сая дөчин гурван мянга]-н төгрөгийг төсөвлөсөн бөгөөд байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө болох тус зардлын 50 % буюу 16,021,500 [арван зургаан сая хорин нэгэн мянга таван зуу]-н төгрөгийг төрийн сангийн 100900013406 тоот дансанд тушаав.

Хүснэгт 17. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Байгаль хамгаалах төлөвлөгөө	Зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	14,450.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	10,400.0
3	Дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөө	7,900.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,350.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,700.0
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	500.0
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	4,483.0
8	Нийт зардал	32,043.0

1.1.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө							
Д/д	Учруулах сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Хэмжих нэгж, тоо ширхэг	Шаардагдах зардал, ман.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Хариуцах албан тушаалтан	Баримтлах эрхзүйн баримт бичиг
0	1	2	3	4	5	6	7
1.1.1. Агаарын чанарт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө							
1.	Үйл ажиллагааны явцад тоосжилт үүсч орчны агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэх,	Уурхайн карьер, овоолго, зам, талбайн усалгааны хэмжээ, норм, горимыг сар, улирлаар оновчтой тогтоож бүртгэл хөтлөн ажиллах	20 тн-ийн багтаамжтай усны машинаар өдөрт 4-5 удаа	ҮАЗ	Тухайн жилд бороо, цастай өдрөөс бусад үед	Уулын мастер, Байгаль орчны мэргэжилтэн	ЗТБХБ-ын сайдын 2011 оны 216 тоот тушаал. MNS4585:2007,
2.	Авто машин, техникээс ялгарах хорт хийний нөлөөгөөр агаарын чанар муудах,	- Хүнд механизмын утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байгаа эсэхэд хяналт тавьж хэмжилт хийх, - Хөдөлгүүрээс гарах утааны найрлага стандартад заасан хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд шүүлтүүр, гүйцэд исэлдүүлэх хэрэгсэл төхөөрөмж тавих	Уурхайд ашиглаж буй нийт хүнд машин механизм-д	ҮАЗ	Сард нэг удаа	Механик, Байгаль орчны мэргэжилтэн	

3.		Уурхайн карьер, овоолгод ажиллаж байгаа ачих буулгах, тээвэрлэх машин техникийн кабин доторх агаарыг цэвэршүүлэх төхөөрөмж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч байх	Уурхайд ашиглаж буй нийт хүнд машин механизм-д	650.0	Сард нэг удаа	Механик, ХАБ хариуцсан ажилтан, Байгаль орчны мэргэжилтэн	
4.	5.	Замын ачааллын хяналтыг тэнцвэржүүлэх. Шороон замаар зорчих ачааны, автомашинуудын хоорондын зайг 20 секундээс 30 м-с их байхаар хугацаа болон хоорондох зайг тогтоосон тэмдэг байршуулах	Уурхайн дотоод тээврийн зам дагуу	300.0	Тухайн жилд	ХАБ хариуцсан ажилтан	
6.							
6.		Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах, тэдэнд сургалт, сурталчилгаа явуулах	Уурхайн нийт ажилчид	ХАБ-ын зардал	Тогтмол	ХАБ хариуцсан ажилтан	
7.	Хөрс хуулах, нүүрс олборлоход тэсэлгээ явуулснаар агаар орчинд их хэмжээний дуу шуугиан, чичиргээ болон тоосжилт үүсгэж улмаар хөрсний найрлага дахь эрдсийн жижиг тоосонцор үүсэх,	- Өрөмдлөгийн үед усаар чийгшүүлж байх, - Салхи, шуурга ихтэй үед тэсэлгээний ажил явуулахгүй байх - Тэсэлгээний ажлыг өдрийн цагаар явуулах	-	ҮАЗ	Өрөмдлөг, тэсэлгээний ажил гүйцэтгэх үед мөрдөх ажиглах	Гэрээт компани	
1.1.2. Хөрсөн бүрхэвч, гадаргын хэлбэрт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах							

1.		Шинээр эвдрэлд өртөх талбайн шимт хөрсийг 0.2 м зузаантай хуулж овоолго үүсгэн хадгалах	м3	ҮА3	Шинээр газар шорооны ажил эхлэх үед	Уулын инженер, Уулын мастер, Байгаль орчны	
2.		ШТМ-аар хөрс бохирлогдсон тохиолдолд саармагжуулах, аюулгүй болгох арга хэмжээ авах	м2	500.0	Асгаралт үүссэн тохиолдолд	Байгаль орчны мэргэжилтэн, механик	
3.		- Машин механизмын засвар үйлчилгээг тусгай зориулалтын талбайд хийх, хучилт хийх, урсгал засварыг тогтмол гүйцэтгэх - Ахуйн хатуу, шингэн хог хаягдал болон химийн бодисыг эмх цэгцтэй хадгалах, устгах, зайлуулах, тогтмол хяналт тавьж ажиллах	-	ҮА3	Үйл ажиллагааны турш	Байгаль орчны мэргэжилтэн, механик	
4.		Хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	Нийт ажилчдад	ҮА3	3-р улиралд	Байгаль орчны мэргэжилтэн	
5.		Уурхайн үйл ажиллагаанаас хөндөгдсөн газарт мониторинг хийж холбогдох арга хэмжээг тухай бүр авах	м3	ҮА3	Эвдрэл үүссэн тохиолдолд	Байгаль орчны мэргэжилтэн	

1.1.3. Гадаргын болон газрын доорх усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах							
6.	Төсөл хэрэгжиж буй талбайн газрын доорх усны нөөц хомсдох	ШТМ хөрсөнд шууд асгарсан тохиолдолд түүнийг саармагжуулах, зайлуулах арга хэмжээг авч ажиллах	м2	ҮА3	Асгаралт үүссэн тохиолдол бүрт	Байгаль орчны мэргэжилтэн	
7.	шүүрлийн ус шавхалтаас газрын доорх усны горим, нөөцөд сөргөөр нөлөөлж усны түвшин буурч болзошгүй	Шүүрлийн усыг татан зайлуулж хөв цөөрөм байгуулахтай холбоотой усны мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгэх, зураг төсөл гаргуулах.	-	5,000.0	2026 оны 4-р улиралд багтааж	Байгаль орчны мэргэжилтэн	
1.1.4. Ургамал ба амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ							
8.	Уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөр ургамлан нөмрөг устгах	Барилга байгууламж, ажилчдын хотхоны гадна талбайд ногоон байгууламж бий болгох: - Хотхоны гадна 500 ширхэг Хайлаас, Шар хуайс мод тарьна, - Уурхайн хотхоны гадна талбайг зүлэгжүүлэх	0.06 га	6,000.0	2026 оны Хавар	Байгаль орчны мэргэжилтэн	Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хууль,
9.	Уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөр зэрлэг амьтад дайжих, амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх	Зэрлэг амьтдын амьдардаг гол тархац нутаг, уст цэг орчимд хужир шүү, тэжээл тавих, өвөл хаврын хуурайшилт ихтэй үед усан хангамжийг сайжруулах зэргээр биотехнологийн арга хэмжээг орон нутгийн Байгаль хамгаалагчтай хамран зохион байгуулна. - Өвс тараах- 100 боодол	Га	2,000.0	2026 оны Хавар	Байгаль орчны мэргэжилтэн	Амьтны тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль
	Нийт зардал			14,450.00			

1.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө						
Д/д	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ буруулах арга хэмжээний төлөвлөгөө	Хэмжих нэгж, тоо ширхэг	Шаардагдах зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Хариуцах албан тушаалтан	Баримтлах эрхзүйн баримт бичиг
0	1	2	3	4	5	6
1.	Биологийн нөхөн сэргээлт хийхэд шаардагдах үрийн нөөцийг бүрдүүлэх зорилгоор нутгийн ургамлын үр түүх, нөхөн сэргээлтийн туршилт судалгааны талбай бий болгох.	0.5 га	10,400.0	2026 оны Хавар	Уулын мастер, Байгаль орчны мэргэжилтэн	
	Нийт зардал		10,400.0			

1.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө						
Д/д	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ буруулах арга хэмжээний төлөвлөгөө	Хэмжих нэгж, тоо ширхэг	Шаардагдах зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Хариуцах албан тушаалтан	Баримтлах эрхзүйн баримт бичиг
0	1	2	3	4	5	6
1.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээнд тариалах модлог ургамлын төрөл зүйлийг өсгөж үржүүлэх плантац, үржүүлгийн талбай байгуулах /- Орон нутгаас зааж өгсөн талбайд тухайн бүсийн уур амьсгал, хөрсний хэв шинжид тохирсон модлог ургамал тарьна./	га	7,900.0	2026 оны Хавар	Байгаль орчны мэргэжилтэн	
	Нийт зардал	7,900.0				

1.4. Хог хаягдлын менежментийн төлвөлөгөө						
Д/д	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ буруулах арга хэмжээний төлөвлөгөө	Хэмжих нэгж, тоо ширхэг	Шаардагдах зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Хариуцах албан тушаалтан	Баримтлах эрхзүйн баримт бичиг
0	1	2	3	4	5	6
1.	Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин ашигладаг тогтолцоог нэвтрүүлэх	га	100.0	2026 оны Хавар	Байгаль орчны мэргэжилтэн	
2.	Ахуйн хог хаягдлын гэрээг Баянжаргалан сумын ЗДТГазартай байгуулах	-	ҮАЗ	2026 оны эхний улиралд багтааж	Байгаль орчны мэргэжилтэн	
3.	Төслийн талбайд үүссэн ахуйн хатуу хог хаягдлыг цуглуулж сумын нэгдсэн хогийн цэгт хүргэх	3-4 удаа	ҮАЗ	Хуваарийн дагуу тогтмол	Байгаль орчны мэргэжилтэн	
4.	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр, оффис, агуулах, ШТС зэрэг газарт байрлуулах, засварлаж байх	Шаардлагатай газруудад нэмж байршуулна.	500.0	2026 онд	Байгаль орчны мэргэжилтэн	

5.	Хог хаягдал түр хадгалах цэгийн талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий суурьтай болгон тохижуулах	м2	1,000.0	2026 онд	Байгаль орчны мэргэжилтэн	
6.	Хийсэж тархсан болон үүссэн хог хаягдлын овоолгыг тогтмол цэвэрлэж хэвших	-	ҮАЗ	2026 онд	Байгаль орчны Мэргэжилтэн, кемп менежер	
7.	Дахин ашиглах боломжтой ахуйн гаралтай хатуу хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт гэрээлэн нийлүүлэх ажлыг тогтмол хэрэгжүүлэх	кг	ҮАЗ	Үүсэх хэмжээнээс хамааран тогтмол	Байгаль орчны Мэргэжилтэн	
8.	Бие засах газар, бохир усны цооногийг тогтмол ариутгаж, халдваргүйжүүлж байх	-	ҮАЗ	Хувиарын дагуу тогтмол	Байгаль орчны Мэргэжилтэн	
9.	Ашигласан тос, тосолгооны материал, аккумуляторыг тусгай цэг гарган хуримтлуулах, түр хуримтлуулах цэгийг тохижуулах	-	ҮАЗ	2026 оны 2-р улиралд	Байгаль орчны Мэргэжилтэн	
10.	Ашигласан тос тосолгооны материалыг дахин боловсруулах үйлдвэрт гэрээний дагуу нийлүүлэх.	тн	ҮАЗ	Гэрээний дагуу	Байгаль орчны Мэргэжилтэн	

11.	Хөрс шатах тослох материалаар бохирдсон тохиолдолд бохирдсон хэсгийг ялган авч саармагжуулах арга хэмжээ авах	м2	ҮАЗ	Бохирдол үүссэн тохиолдолд	Байгаль орчны Мэргэжилтэн	
12.	Хог хаягдлын нэгдсэн бүртгэлийг хөтлөх. Хог хаягдлын бүртгэл, баталгаажуулалтыг үргэлжлүүлэн гүйцэтгэх. Хог хаягдалтай холбоотой бүх төрлийн мэдээллийг баримтжуулж, мэдээллийн сан үүсгэж байх. Баримтжуулалтын хүрээнд дараах үндсэн мэдээллийг хөтлөх. Үүнд: - Хог хаягдлын төрөл, - Хог хаягдлын хэмжээ, - Хог хаягдлын хэрхэн ангилсан, хог хаягдлыг хэрхэн зайлуулсан тухай мэдээлэл	-	ҮАЗ	Тогтмол	Байгаль орчны Мэргэжилтэн	
	Нийт зардал		1,700.0			

1.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох олгох төлөвлөгөө

Ашиглалт явуулж буй MV-020772 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хөөтийн хонхор-2” нэртэй нүүрсний ордын талбайд айлын өвөлжөө, хаваржаа байхгүй тул энэ чиглэлээр БОМТ-нд тодорхой ажил тусгагдахгүй болно. Гэвч цаашид нүүлгэн шилжүүлж нөхөн олговор олгох шаардлага гарвал харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

1.6. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Өмнөх олборлолтын үе болон БОННУ-ний хээрийн хэмжилт судалгааны үеэр АМТЗ-ийн талбайд нүдэнд ил харагдах түүх соёлын дурсгалт зүйлс ажиглагдаагүй байна. Гэвч бид “Түүх соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийг сахин биелүүлэх үүднээс хэрэв уурхайлалт болон уурхайн бэлтгэл шатны барилга байгууламж, зам талбайн ажлыг хийж байх үед газрын гүнээс түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл уулын ажлыг зогсоон сумын ЗДТГ, мэргэжлийн зохих байгууллагад яаралтай мэдэгдэж, авран хамгаалах, цаашлаад нүүлгэн шилжүүлэх ажлыг гүйцэтгэх хэрэгтэй. Мөн төсөл хэрэгжүүлэгч нь тухайн бүс нутгийн соёлын биет бус өвийг хамгаалах, хадгалах чиглэлээр компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд тодорхой ажил төлөвлөн хэрэгжүүлж болно.

1.7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө						
Д/д	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ буруулах арга хэмжээний төлөвлөгөө	Хэмжих нэгж, тоо ширхэг	Шаардагдах зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Хариуцах албан тушаалтан	Баримтлах эрхзүйн баримт бичиг
0	1	2	3	4	5	6
1.7.1. Байгалийн гамшигт үзэгдлийн улмаас үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ						
1.	Цаг агаарын урьдчилсан мэдээлэлд тулгуурлан уурхайн үйл ажиллагааг байгальд ээлтэйгээр зохицуулах	-	ҮАЗ	Тогтмол	Уурхайн дарга, ХАБ хариуцсан ажилтан	Гамшгын эрсдлийн үнэлгээ, Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө
1.7.2. Гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө						
2.	Бүх ажилчдыг гал түймэр унтраах мэргэжлийн сургалтад хамруулах	Уурхайд ажиллаж буй хүний тоогоор	250.0	2026 оны 4-р улиралд багтааж	ХАБ хариуцсан ажилтан	Галын аюулгүй байдлын тухай хууль, 16-р зүйл, MNS5566:2008 MNS0640:89 MNS639:89
3.	Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах, Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах хуурайшилт ихтэй саруудад гал унтраах хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналтыг ойртуулах тавих	-	400.0	Тогтмол	ХАБ хариуцсан ажилтан	

1.7.3. Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ						Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, MNS 4990:2023 MNS 4969:2000
4.	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах	Ээлжинд гарч буй нийт ажилчдад	ХАБЭА-н зардал	Тогтмол	ХАБ хариуцсан ажилтан, Уулын мастер	
5.	Ажилчин нэг бүрийг хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгслээр хангах	Уурхайд ажиллаж буй нийт ажилчдад	ХАБЭА-н зардал	2026 оны 4-р улиралд	ХАБ хариуцсан ажилтан	
6.	Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	Уурхайд ажиллаж буй нийт ажилчдад	1,700.0	2026 оны 4-р улиралд багтаан	ХАБ хариуцсан ажилтан	
7.	Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг машины кабин, ажлын байрт байрлуулах	-	ХАБЭА-н зардал	Тогтмол	ХАБЭА хариуцсан ажилтан	
8.	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах төлөвлөлтийг хийх, хэрэгжүүлэх	Нийт ажилчид	ХАБЭА-н зардал	2026 оны 4-р улиралд багтааж	Гүйцэтгэх захирал, уурайн эмч	
Нийт зардал		2,350.0				

1.8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө						
Д/д	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ буруулах арга хэмжээний төлөвлөгөө	Хэмжих нэгж, тоо ширхэг	Шаардагдах зардал,	Хэрэгжүүлэх хугацаа, давамж	Хариуцах албан тушаалтан	Баримтлах эрхзүйн баримт бичиг
0	1	2	3	4	5	6
1.	Байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх;	-	ҮАЗ	2026 оны Хавар	Байгаль орчны мэргэжилтэн	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 101, БОНБУ-ний тухай хууль
2.	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ Байгаль орчны асуудлыг удирдлагын түвшний ажилтанд хариуцуулж, хяналт тавин ажиллах; Ажилтнуудад байгаль орчны сургалтуудыг ажлын байранд нь зохион байгуулах	-	500.0	2026 онд батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу	Байгаль орчны мэргэжилтэн	
	Нийт зардал			500.0		

БҮЛЭГ 5. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг мян.төг	Нийт зардал, мян.төг /жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал	Дээд доод хязгаар
5.1. АГААРЫН ЧАНАР								
1	Агаар дахь тоосжилтын хяналт: Нийт тоос (TSP), PM2.5, PM10 Тоосны уналт	Ил уурхайн салхины чиглэлийн доор Уурхайн тосгон Ажлын байр Карьерын дотор дээд, дунд, доод хэсэг	Жилд 4 удаа буюу улирал тутам	Тоосжилтын хяналтын явуулах мониторингийн 7 цэгт	33.0	925.0	MNS 4585:2016 MNS:3384:1982 MNS:4048:1988	PM2.5- 0.05 мг/м3 PM10- 0.1мг/м3
2	Бохирдлын цэгэн эх үүсвэр: SOx, NOx, COx	Уурхайн гадаад, дотоод тээврийн замын хажууд	Жилд 4 удаа буюу улирал тутам	Бохирдуулагч хийн хяналт шинжилгээ явуулах мониторингийн 2 цэгт	50.0	100.0	MNS 4585:20216 MNS:3384:1982 MNS 4048:1988	ЗДХ
5.2. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УС								
1	Гадаргын болон газрын доорх усны чанар: Гол ионы найрлага: анион, катион, микро	Уурхайн худаг бүрээс Уурхайн шүүрлийн уснаас /1 цэгээс / Булаг - Мониторингийн	Жилд 4 удаа	Нийт 4 цэг дээр дээжлэлт хийж шинжлэх	43.0	688.0	MNS (ISO) 5667- 1:2002 MNS (ISO) 5667- 1:2004 MNS ISO 5667- 5:2001 MNS 900-2018 MNS 6148:2010 MNS 4586 : 1998	ЗДХ

	элементийн агууламж,	цооног /шинээр байгуулна/						
2	Ундны усны микробиологийн хяналт шинжилгээ	Унд ахуйн ус	Жилд 4 удаа	Унд ахуйн хэрэглээний ус	37.5	150.0	MNS 900-2018	ЗДХ
	Газрын доорх усны түвшин, хэмжих	Мониторингийн цооног	Улиралд нэг удаа	Нийт 2 цэг дээр хэмжилт	-	-	Хуваарийн дагуу	
5.3. ХӨРСӨН БҮРХЭВЧ								
1	Хөрсний ерөнхий химийн үзүүлэлтүүдийг хянах	-Засварын газар -Хог хаягдлын цэг -ШТМ-ын Агуулах - Шимт хөрсний овоолго, - Ил уурхайн дэргэд, - Нөхөн сэргээлт хийсэн талбай,	Жилд 3 удаа Дулааны улиралд авах	Уурхайн бүсийн орчим мониторингийн 7 ш тогтмол цэгт	25.0	525.0	MNS 5850 : 2019 MNS 3298 : 1991	ЗДХ
2	Хөрсний бохирдлын хэмжилт (цацраг идэвхт элементүүд, хүнд металлууд, нефть бүтээгдэхүүн,	- Шатахуун ачих, буулгах, машин механизмыг шатахуунаар цэнэглэх талбай, агуулах	Жилд 3 удаа Дулааны улиралд авах	Уурхайн бүсийн орчим мониторингийн 3 ш тогтмол цэгт	25.0	225.0	MNS5850 : 2019	ЗДХ

	органик Бохирдуулаг)	орчимд -Уурын зуух - Хог хаягдал бохирын цэгийн орчимд						
5.4. УРГАМЛАН НӨМРӨГ								
	Ургамлын төрөл зүйл, бүрхэц %, ургамлын дундаж өндөр, Газрын гадаргуугаас дээшхи ургамлын биомасс, кг/га	Нийт тусгай зөвшөөрөл бүхий талбайд	Жилд 3 удаа ургамал ургалтын хугацаанд	Ургамлын хяналт шинжилгээг мониторингийн 3-5 цэгт		600.0	MNS5850:2019	ЗДХ
5.5. ДУУ ЧИМЭЭ ДОРГИО ЧИЧИРГЭЭ								
	Гадаад орчны дуу чимээ	Нийт тусгай зөвшөөрөл бүхий талбайд	Жилд нэг удаа	Хяналт шинжилгээ явуулах 2 мониторингийн цэг дээр		100.0	MNS4585:2016	60 дБ
	Ажлын байрны дуу, чимээ	Ил уурхайн орчимд	Жилд нэг удаа	Шаардлагатай ажлын байруудад		100.0		85 дБ
НИЙТ ОХШХ-ИЙГ ХЭРЭГ ЖҮҮЛЭХ НИЙТ ЗАРДАЛ 4,483.0 МЯН.ТӨГ								

**БҮЛЭГ 6. БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ,
ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ**

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа тов
	1	2	3	4
1	Баянжаргалан сумын 2-р багийн иргэд	ИНХ-д танилцуулах	Тухайн жилд хийгдсэн ажил	Тухайн оны 4-р улирал
2	Дундговь аймгийн Байгаль орчны газар	https://eic.mn/envmng/ буюу Байгаль орчны мэдээллийн санд оруулах	Тухайн жилд байгаль орчны талаар хийгдсэн ажил нөхөн сэргээсэн ажлын акт болон холбогдох материал	Тухайн оны 11 - р сарын 1 дотор
3	Төрийн захиргааны төв байгууллага	https://eic.mn/envmng/ буюу Байгаль орчны мэдээллийн санд оруулах, тамгалуулах		Тухайн оны 12 - р сарын 1 дотор

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

1. Аж ахуй нэгжийн Улсын бүртгэлийн гэрчилгээ
2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ
3. Газар эзэмших эрхийн гэрчилгээ
4. Байгаль орчны АУДИТ-ын тайлан, дүгнэлт
5. 2026 Оны Уулын ажлын төлөвлөгөө
6. Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө байршуулсан төлбөрийн баримт